



МОНГОЛБАНКНЫ ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ТУШААЛ

2021 оны 06 сарын 30 өдөр

Дугаар А-162

Улаанбаатар хот

Урт хугацаат своп хэлцлийн журмыг шинэчлэн батлах тухай

Төв банк /Монголбанк/-ны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, 28 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1, 2 дахь заалт, Валютын зохицуулалтын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсэг, 10 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. “Урт хугацаат своп хэлцлийн журам”-ыг хавсралт ёсоор шинэчлэн баталсугай.
2. Батлагдсан журмыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлж ажиллахыг бүх банкны гүйцэтгэх захирал нарт тус тус үүрэг болгосугай.
3. Энэ тушаалыг батлагдсан өдрөөс эхлэн үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг Нөөцийн удирдлага, санхүүгийн зах зээлийн газар (А.Энхжин), Санхүү бүртгэлийн газар (Ц.Гарьд), Эрсдэлийн удирдлагын алба (Д.Баянзул)-нд тус тус үүрэг болгосугай.
4. Энэ тушаал гарсантай холбогдуулан Монголбанкны Ерөнхийлөгчийн 2016 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн А-341 дүгээр тушаалын 1 дэх заалтыг хүчингүй болсонд тооцсугай.
5. Энэхүү тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Дотоод аудитын газар (Т.Амарсайхан)-т даалгасугай.

ЕРӨНХИЙЛӨГЧ



Б.ЛХАГВАСҮРЭН

14 0955

УРТ ХУГАЦААТ СВОП ХЭЛЦЛИЙН ЖУРАМ

НЭГ. Нийтлэг үндэслэл

- 1.1. Энэ журмын зорилго нь гадаад валютын урсгалыг нэмэгдүүлэх, зээлийн хүү, гадаад валютын зээлийн өсөлтийг бууруулах, гадаад валютын ханшийн эрсдэлээс хамгаалах тогтолцоог бий болгохын тулд банкууд урт хугацаат гадны эх үүсвэрээр Монголбанкттай своп хэлцэл байгуулах үйл ажиллагаанд баримтлах зарчим, талуудын эрх, үүрэг, бусад харилцааг зохицуулахад оршино.
- 1.2. Монголбанк нь урт хугацаат своп хэлцлийг арилжааны банк /цаашид Банк гэх/-наас гадна Монгол Улсын Засгийн Газар, олон улсын санхүүгийн байгууллагатай байгуулж болно. Монголбанкнаас тусгайлан заагаагүй бол уг хэлцлийн нөхцөл, зарчим нь Банктай байгуулж буй урт хугацаат своп хэлцэлтэй ижил байна.
- 1.3 Монголбанк нь дараах шаардлагыг хангасан урт хугацаат гадаад эх үүсвэрээр хэлцэл байгуулах саналыг хүлээн авна:
- 1.3.1. Бага хүүтэй, бодит эдийн засгийг дэмжихэд чиглэсэн байх,
 - 1.3.2. Банкны активыг барьцаалаагүй байх, Үүнд Монгол Улсын Засгийн газар болон Хөгжлийн банкнаас гаргасан үнэт цаас 2023 он дуусталх хугацаанд хамаарахгүй¹,
 - 1.3.3. Банкны гадаад валютын нээлттэй позицийн тайланд тусгагдсан байх,
 - 1.3.4. Банкны гадаад гүйлгээний өдрийн мэдээнд тусгагдсан байх,
 - 1.3.5. Банк, аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн гадаад зээлийг бүртгэх журмын дагуу эх үүсвэрийг банкны гадаад зээлийг бүртгэх маягтад бүртгүүлсэн байх.
- 1.4 Энэ журам нь Монголбанкны банктай хийх своп хэлцэл/гэрээний нөхцөл болох бөгөөд банк энэ журмын 4 дэх хэсэгт заасны дагуу саналаа ирүүлснээр своп хэлцлийн нөхцөлийг хүлээн зөвшөөрсөнд тооцно.

ХОЁР. Нэр томъёоны тодорхойлолт

- 2.1 Энэ журамд хэрэглэсэн дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно.
- 2.1.1. **“Урт хугацаат ам.долларын своп хэлцэл”** /цаашид своп хэлцэл гэх/ гэж хэлцэл хийгдэх үед Монголбанк ам.долларын эх үүсвэр татаж, төгрөг нийлүүлж, хугацааны дундуур болон эцэст талууд хүүний төлбөрийг солилцож, зөвхөн эх үүсвэрийн ханшийн зөрүүг төлөх мөнгөн урсгал бүхий 360 хоног буюу түүнээс дээш хугацаатай хэлцлийг;
 - 2.1.2. **“Z спрейд”** гэж АНУ-ын Засгийн газрын үнэт цаастай харьцуулсан Монгол Улсын Засгийн газрын үнэт цаасны эрсдэлийн урамшууллыг;
 - 2.1.3. **“Гадаад зээл, өрийн хэрэгсэл”**, гэж Монгол Улсад бүртгэлгүй, байнгын бус оршин суугч этгээдээс олгосон өр үүсгэх хөрөнгийн эх үүсвэрийг;

¹ Монголбанкны Ерөнхийлөгчийн 2022 оны 10 дугаар сарын 06-ны өдрийн А-283 тушаалаар нэмсэн.

2.1.4. “Бонд” гэж гадаад зах зээл дээр гаргасан дунд болон урт хугацааны үнэт цаасыг.

ГУРАВ. Своп хэлцлийн үндсэн нөхцөл

- 3.1. Энэ журмын нэгдүгээр хавсралтад заасны дагуу своп хэлцлийн нөхцөлийг тодорхойлно.
- 3.2. Энэ журмын хоёрдугаар хавсралтад заасан аргачлалын дагуу Z-спрэдийг тооцно.
- 3.3. Своп хэлцлийн хүүг хэлцэл байгуулсан өдрөөс хойш 3 сар тутам шинэчлэх бөгөөд Монголбанк энэ журмын гуравдугаар хавсралтын дагуу шинэчилсэн хүүг цахим хэлбэрээр банканд хүргүүлнэ.
- 3.4. Хүү тооцох, төлбөр тооцоо хийгдэх өдөр амралтын өдөр, нийтээр амрах баярын өдөр тохиовол дараагийн ажлын өдөр төлбөр тооцоог гүйцэтгэнэ.
- 3.5. Банк нь Монгол Улсад гадаад эх үүсвэрийг оруулж ирсэн өдрөөс хойш 3 сарын дотор Монголбанкттай шинээр хэлцэл байгуулах хүсэлтийг ирүүлж болно.
- 3.6. Своп хэлцлийн төгрөгийн эх үүсвэрт АСТ/365, ам.долларын эх үүсвэрт АСТ/360 хоногийн суурийг тус тус ашиглана.
- 3.7. Төгрөгөөр илэрхийлэгдсэн мөнгөн дүн нь төгрөг, мөнгө гэсэн бүтэцтэй байна.
- 3.8. Бонд, гадаад зээл, өрийн хэрэгслийн ам.доллароос бусад валютаарх эх үүсвэрийг ам.долларт хөрвүүлж, тус эх үүсвэрээр своп хэлцэл хийх хүсэлтийг Монголбанканд ирүүлж болно.
- 3.9. Банк нь зээлийн гэрээний хугацааг сунгасан, бондыг дахин санхүүжүүлсэн өдрөөс хойш 3 сарын дотор своп хэлцлийн хугацааг сунгах хүсэлтийг Монголбанканд ирүүлж болно.
- 3.10. Банк своп хэлцлийн үүргийг биелүүлээгүй тохиолдолд энэ журмын 7-д заасан арга хэмжээ авна.

ДӨРӨВ. Своп хэлцлийн зарчим

- 4.1. Банк нь своп хэлцэл байгуулах үндэслэлээ энэ журмын дөрөвдүгээр хавсралтын дагуу гарын үсэг, тамга тэмдгээр баталгаажуулан Монголбанканд урьдчилан ирүүлэх бөгөөд дараах баримтыг хавсаргасан байна.
 - 4.1.1. Гадаад зээлийн санхүүжилтын гэрээний баталгаажуулсан хувь
 - 4.1.2. Бондын арилжааны баримт
- 4.2. Энэ журмын 4.1.1-д заасан баримтад дараах мэдээлэл тусгагдсан байна.
 - 4.2.1. Санхүүжилтийн дүн
 - 4.2.2. Санхүүжилтийн хугацаа
 - 4.2.3. Хүү
 - 4.2.4. Эргэн төлөлтийн хуваарь
 - 4.2.5. Бусад нөхцөл
- 4.3. Энэ журмын 4.1.2-г заасан баримтад дараах мэдээлэл тусгагдсан байна.
 - 4.3.1. Бондын арилжааны дүн

- 4.3.2 Өгөөж, купоны хувь хэмжээ
- 4.3.3 Купоны төлөлтийн хуваарь
- 4.3.4 Бусад нөхцөл

4.4. Банк нь своп хэлцлийг энэ журмын тавдугаар хавсралтын дагуу хэлцэл байгуулах ажлын өдөр 11:00 цагаас өмнө гарын үсэг, тамга тэмдгээр баталгаажуулан Монголбанканд хүргүүлнэ.

4.5. Нөөцийн удирдлага, санхүүгийн зах зээлийн газар (цаашид НУСЗЗГ гэх) нь банкнаас энэ журмын дөрөв, тавдугаар хавсралтын дагуу ирүүлсэн своп хэлцэл байгуулах санал болон бусад баримтыг судалж, биелсэн хэлцлийг 15:00 цагаас өмнө Санхүү бүртгэлийн газар (цаашид СБГ гэх)-т хүргүүлнэ.

4.6. СБГ нь своп хэлцлийг хэлцэл байгуулсан өдөр бүртгэж, төлбөр тооцоог гүйцэтгэнэ.

4.7. Монголбанк банкнаас төлбөрийн даалгавар ирсэн эсэхээс үл хамаарч хүүний болон үндсэн төлбөрийн гүйлгээг хийнэ.

4.8 Энэ журмын 3.9-д заасан своп хэлцэл сунгах хүсэлт нь дараах шаардлагыг хангасан байна:

4.8.1 Байгуулсан своп хэлцлийн ханшийн зөрүүг солилцож, хэлцлийг тухайн үеийн журмын нөхцөлийн дагуу шинэчлэн байгуулна.

4.8.2 Хэлцлийн үндсэн дүнг нэмж сунгах тохиолдолд нэмэгдсэн эх үүсвэр нь энэ журмын 1.3.3-1.3.5-д заасан шаардлагыг хангасан байна.

4.8.3 Хэлцлийн үндсэн дүнг бууруулж сунгах тохиолдолд буурсан эх үүсвэрт 1.3.3-1.3.5 дахь заалтууд хамаарахгүй болно.

4.9. Ногоон таксономигийн (цаашид “ногоон санхүүжилт” гэх)² ангилалд багтсан зээлийн эх үүсвэрт ам.долларын хүүнд 0.5%-ийг нэмж тооцож болно.

4.10. Энэ журмын 4.9 дэх заалтын дагуу ногоон санхүүжилтийн ангилалд багтсан зээлийн эх үүсвэрт ам.долларын хүүнд 0.5% нэмж олгосон тохиолдолд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ³:

4.10.1 Банк нь урт хугацаат своп хэлцлийн эх үүсвэрээс олгосон ногоон зээлийн тайланг хэлцэл тус бүрээр улирал болгоны эхний долоо хоногт болон хэлцлийн хугацаа дуусах өдрөөс ажлын 5 хоногийн өмнө цахимаар Монголбанканд ирүүлж, албан бичгээр баталгаажуулна.

4.10.2 Монголбанк нь банкнаас ирүүлсэн тайланг хянаж, урт хугацаат своп хэлцлийн эх үүсвэрээс ногоон зээлд олгоогүй дүнд нэмж олгосон 0.5%-ийн хүүний төлбөрийг тухайн банкны данснаас үл маргах журмаар суутгана.

4.10.3 Банк нь урт хугацаат своп хэлцлийн эх үүсвэрээс олгосон ногоон зээлийн тайланг хэлцлийн хугацаа дуусахаас ажлын 5 хоногийн өмнө Монголбанканд ирүүлээгүй тохиолдолд өмнөх улирлын тайлангийн гүйцэтгэлийг үндэслэл болгоно.

² Монголбанкны Ерөнхийлөгчийн 2022 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн А-7 дугаар тушаалаар нэмсэн.

³ Монголбанкны Ерөнхийлөгчийн 2022 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн А-7 дугаар тушаалаар нэмсэн.

- 4.10.4 Банк нь урт хугацаат своп хэлцлийн эх үүсвэрээс олгосон ногоон зээлийн тайланг Монголбанканд ирүүлээгүй тохиолдолд нэмж олгосон 0.5%-ийн хүүний бүх төлбөрийг банкны данснаас үл маргах журмаар суутгана.

ТАВ. Талуудын эрх

5.1. Монголбанк дор дурдсан эрхтэй:

5.1.1. Своп хэлцэлтэй холбоотой тайлан, мэдээ, мэдээлэл, баримтыг банкнаас гаргуулан авах;

5.1.2. Мөнгөний бодлого, валютын захын тухайн үеийн болон хүлээгдэж буй нөхцөл байдал, банкны өр төлбөрөө төлөх чадвар, бусад хүчин зүйлсийг харгалзан үзэж своп хэлцэл хийх, банкны саналыг хэсэгчлэн, эсвэл бүрэн хэмжээгээр биелүүлэхээс татгалзах, татгалзсан шалтгаанаа тайлбарлахгүй байх.

5.2. Банк дор дурдсан эрхтэй:

5.2.1. Энэ журмын 6.2.1-д заасан гадаад зах зээлээс татсан эх үүсвэрийн 100 хүртэлх хувиар своп хэлцэл байгуулах саналыг Монголбанканд ирүүлэх;

5.2.2. Энэ журмын шаардлагыг хангасан своп хэлцэл байгуулах, сунгах хүсэлтийг Монголбанканд ирүүлэх.

ЗУРГАА. Талуудын үүрэг

6.1. Монголбанк дор дурдсан үүрэгтэй:

6.1.1. Монголбанк нь банк тус бүртэй байгуулсан своп хэлцэл, энэ журмын 5.1.1-д заасан мэдээллийн нууцлалыг хангах;

6.1.2. Энэ журамд нэмэлт, өөрчлөлт орсон тохиолдолд ажлын 2 өдрийн дотор банкинд мэдэгдэх;

6.1.3. Своп хэлцлийн төлбөр тооцоог саадгүй гүйцэтгэх.

6.2. Банк дор дурдсан үүрэгтэй:

6.2.1 Своп хэлцлийн ам.долларын эх үүсвэрийг гадаад зээл, өрийн хэрэгсэл, бонд хэлбэрээр гадаад зах зээлээс татан төвлөрүүлэх;

6.2.2 Банк нь хэлцэл хийх үед шаардлагатай ам.долларыг Гадаадын банк дахь харилцах данснаас татаж Монголбанк дахь харилцах дансанд хүрэлцэхүйц хэмжээгээр байршуулах;

6.2.3 Хүү, үндсэн төлбөр төлөгдөх үед Монголбанк дахь төгрөгийн харилцах дансанд хүрэлцэхүйц хэмжээгээр байршуулах;

6.2.4 Монголбанкнаас шийдвэр гаргахад шаардагдах санхүүгийн тайлан, мэдээ, мэдээллийг Монголбанканд заасан хугацааны дотор үнэн, зөв ирүүлэх;

6.2.5 Банкны эрх бүхий ажилтны гарын үсгийн баталгааны өөрчлөлтийн талаар Монголбанканд ажлын 2 өдрийн дотор бичгээр мэдэгдэх;

6.2.6 Свoп хэлцлийн саналын материалыг бүрэн гүйцэд ирүүлснээс хойш ажлын 5 хоногийн дараа саналаа буцааж, цуцлах эрхтэй.

ДОЛОО. Хэлцлийн үүргийг биелүүлээгүй тохиолдолд авах арга хэмжээ

- 7.1. Банк нь энэ журмын 6.2.2 дахь заалтыг зөрчсөн тохиолдолд тус саналыг Монголбанк цуцалж, сануулга хүргүүлнэ.
- 7.2. Энэ журмын 6.2.3-т заасан төлбөр тооцоог гүйцэтгэхэд банкны Монголбанк дахь төгрөгийн харилцах дансны үлдэгдэл хүрэлцэхгүй тохиолдолд Монголбанк төлбөрийн үлдэгдлийг дараах байдлаар төлүүлнэ:
 - 7.2.1. Монголбанк дахь ам.долларын харилцах данснаас тухайн өдөр мөрдөгдөж буй Монголбанкны зарласан албан ханшаар төгрөгт хөрвүүлж, төлүүлнэ.
 - 7.2.2. Монголбанк дахь ам.долларын харилцах дансны үлдэгдэл банкны төлөх төгрөгийн дүнд хүрэлцэхгүй гэж үзсэн бол Банкнаас бусад гадаад валютын харилцах дансны үлдэгдэл, төгрөг, валютын хадгаламжийн үлдэгдэл, эзэмшиж буй ТБҮЦ, ЗГҮЦ-наас суутгаж, төлүүлэхийг баталгаажуулсан энгийн векселийг ажлын 3 хоногийн дотор бичиж ирүүлэхийг шаардана. Уг векселийг үндэслэн Монголбанк холбогдох төлбөрийг төлүүлнэ.
 - 7.2.3. Энэ журмын 7.2.1, 7.2.2-т заасан арга хэмжээг авсны дараа төлбөр барагдаагүй тохиолдолд банкийг хүрэлцэхүйц төгрөг харилцахдаа байршуулах хүртэл хугацаанд алдангийг Монголбанкны овернайт репо санхүүжилтийн хүүг 2 нэгж хувиар нэмэгдүүлж тооцно.
- 7.3. Банк төлбөрийг ЗГҮЦ болон ТБҮЦ-аар барагдуулах тохиолдолд Монголбанк холбогдох журам, зааварт заасны дагуу уг үнэт цаасны зах зээлийн үнэлгээг хийж, уг дүнгээр төлүүлнэ.
- 7.4. Энэ журмын 7.1.3-т заасны дагуу алданги тооцож эхэлснээс хойш банк ажлын 5 хоногт төлбөрийг барагдуулаагүй тохиолдолд Монголбанк хэлцлийн форвард гүйлгээг цуцалж, 7.1-т заасан алдангиас бусад эх үүсвэрийг банкны төгрөгийн харилцах дансанд буцаах бөгөөд хэлцлийн төгрөгийн дүнгийн 0.5 хувьтай тэнцүү мөнгөн торгуулийг ногдуулна.
- 7.5. Энэ журмын 7.1-д заасан сануулга, 7.2, 7.4-т заасан арга хэмжээ тус тус давтагдсан тохиолдолд Монголбанк уг банктai хийсэн свoп хэлцлийг нэг талын санаачилгаар цуцалж, банкны саналыг цаашид хүлээн авахаас татгалзаж болно.
- 7.6. Свoп хэлцлийн хугацаа дуусахаас өмнө шүүх банкны дампуурлыг зарласан тохиолдолд хэлцлийн хүүгийн төлбөр, сүүлийн гүйлгээг цуцална.

“Урт хугацаат своп хэлцлийн журам”-ын
нэгдүгээр хавсралт

СВОП ХЭЛЦЛИЙН ҮНДСЭН НӨХЦӨЛ

д.д	Үзүүлэлтүүд	Нөхцөлүүд
1	Төгрөгийн эх үүсвэрийн хүү	Репо арилжааны хүү
2	Ам.долларын эх үүсвэрийн хүү	<ul style="list-style-type: none"> • Своп хэлцэл: $R_{usd}^4 = SOFR\ 3M + Z\text{-спрейд}^5 + 1.0\%^6$
3	Үндсэн төлбөр солилцох	<p>Хугацааны эцэст:</p> <ul style="list-style-type: none"> • Үндсэн төлбөрийн гүйлгээ хийгдэхгүй. Зөвхөн тухайн өдөр мөрдөгдөж буй Монголбанкнаас зарласан албан ханш, эхний гүйлгээний ханшийн зөрүүг ам.долларын эх үүсвэрийн дүнгээр үржүүлэн, төгрөгөөр төлнө.
4	Хүү төлөх хэлбэр	Хүүний төлбөрийг тухайн өдөр мөрдөгдөж буй Монголбанкнаас зарласан албан ханшаар төгрөгт хөрвүүлж, зөрүүг төлнө.
5	Хүүний төлбөр хийгдэх хугацаа, давтамж	3 сар тутам
6	Эхний гүйлгээний ханш	Хэлцэл байгуулах өдөр мөрдөгдөж буй Монголбанкнаас зарласан албан ханш
7	Сүүлийн гүйлгээний ханш	Эхний гүйлгээний ханштай тэнцүү ханш

⁴ Монголбанкны Ерөнхийлөгчийн 2022 оны 5 дугаар сарын 27-ны өдрийн А-164 тушаалаар LIBOR хүүг SOFR хүү рүү шилжүүлсэн.

⁵ Z-спрейдийг таслалаас хойш хоёр оронгоор тооцно.

⁶ Монголбанкны Ерөнхийлөгчийн 2022 оны 09 дүгээр сарын 16-ны өдрийн А-237 тушаалаар 2023 он дуусталх хугацаанд тогтмол 1.0%-ийг нэмсэн.

“Урт хугацаат своп хэлцлийн журам”-ын
хоёрдугаар хавсралт

Z СПРЕЙД ТООЦОХ АРГАЧЛАЛ

Монгол Улсын Засгийн газрын олон улсын зах зээл дээр хамгийн сүүлд гаргасан ам.долларын бондын зах зээлийн хаалтын үнэд үндэслэн дараах тэнцэтгэлээр Z спрейдийг тооцоолно.

$$P = \frac{R}{\left(1 + \frac{y_N + ZS}{freq}\right)^{(N-1+\frac{DSC}{E})}} + \sum_{k=1}^N \frac{C/freq}{\left(1 + \frac{y_k + ZS}{freq}\right)^{(k-1+\frac{DSC}{E})}}$$

Хэлцэл байгуулах өдөр дээрх бондын өнөөгийн үнэ цэнийн томъёонд Z-спрэдээс бусад үзүүлэлтүүд өмнөх өдрийн байдлаар мэдэгдэж байгаа бөгөөд Z-спрэдийг Excel програмын Solver ашиглан тооцно. Z-спрэд нь хүү шинэчлэх тутам шинэчлэгдэх болно.

Үзүүлэлт	Тайлбар
P	Монгол Улсын Засгийн газрын олон улсын зах зээл дээр хамгийн сүүлд гаргасан ам.долларын бондын өмнөх өдрийн хаалтын үнэ (Last Price)
y_k, y_N	Өмнөх өдрийн байдлаарх АНУ-ын Засгийн газрын үнэт цаасны харгалзах хугацааны өгөөж
ZS	Z спрейд
C	Монгол Улсын Засгийн газрын бондын купон
R	Бондын үндсэн төлбөр
k	Купон төлөгдөх үе
E	Купон төлөгдөх үе хоорондын хугацаа (хоногоор)
DSC	Тухайн бондын үнийг татсан өдрөөс дараагийн купон төлөгдөх хүртэлх хугацаа (хоногоор)
freq	Жилд купон төлөгдөх давтамж
N	Купоны тоо

Эх сурвалж: Блүүмберг

“Урт хугацаат своп хэлцлийн журам”-ын
гуравдугаар хавсралт

УРТ ХУГАЦААТ СВОП ХЭЛЦЛИЙН ХҮҮНИЙ НӨХЦӨЛ

Танай банктай оны сарын ний/ны өдөр байгуулсан дүнтэй урт хугацаат ам.долларын своп хэлцлийн хүүний төлбөр төлөх нөхцөлийг хүргүүлж байна.

1. Хэлцлийн дугаар
2. Банкны нэр
3. Хүүний төлбөр төлөх огноо
4. Хүү тооцох хоног
5. Ам.долларын эх үүсвэрийн хүү*
6. Төгрөгийн эх үүсвэрийн хүү

* “Урт хугацаат своп хэлцлийн журам”-ын нэг, хоёрдугаар хавсралтын дагуу Блүүмберг терминал дахь эх сурвалжид үндэслэн тооцно.

_____оОо_____

УРТ ХУГАЦААТ СВОП ХЭЛЦЭЛ БАЙГУУЛАХ, СУНГАХ ҮНДЭСЛЭЛ

БАНКНЫ НЭР: _____ **ОГНОО:** _____

Д/д	Үзүүлэлтүүд	Тайлбар	Мэдээлэл тусгагдсан баримтын нэр	Гэрээний хуудасны дугаар
1	Санхүүжилтийн төрөл:			
2	Зээлдэгчийн нэр:			
3	Зээлдүүлэгчийн нэр:			
4	Зээлийн зориулалт:			
5	Зээлийн гэрээ байгуулсан огноо:			
6	Санхүүжилт авсан огноо:			
7	Зээлийн төлөгдөх огноо:			
8	Зээлийн хэмжээ:			
9	Тайлант онд татсан хэмжээ:			
10	Зээлийн хүү:			
11	Хүү тооцох давтамж:			
12	Үндсэн төлбөр төлөх давтамж:			

УРТ ХУГАЦААТ СВОП ХЭЛЦЭЛ БАЙГУУЛАХ САНАЛ

Үзүүлэлтүүд		
13	Хэлцлийн хэмжээ:	
14	Хэлцлийн дуусах огноо:	

УРТ ХУГАЦААТ СВОП ХЭЛЦЛИЙГ СУНГАХ ХҮСЭЛТ

Үзүүлэлтүүд		
15	Хэлцлийг сунгах огноо:	
16	Хэлцлийн хэмжээ:	
17	Хэлцлийн дуусах огноо:	
18	Санхүүжилтийн төрөл:	
19	Зээлдэгчийн нэр:	
20	Зээлдүүлэгчийн нэр:	
21	Зээлийн зориулалт:	
22	Зээлийн гэрээ байгуулсан огноо:	
23	Санхүүжилт авсан огноо:	
24	Зээлийн төлөгдөх огноо:	
25	Зээлийн хэмжээ:	
26	Зээлийн хүү:	
27	Хүү тооцох давтамж:	
28	Үндсэн төлбөр төлөх давтамж:	

- Монголбанкны урт хугацаат своп хэлцлийн журамд заасан нөхцөлийг хангаж, үүргийг гүйцэтгэхийг үүгээр хүлээн зөвшөөрч байна.

БАТАЛГААЖУУЛСАН:

(Албан тушаал, Овог, нэр)

(Гарын үсэг) (ТАМГА) Бэлтгэсэн:(Мэдээлэл бэлтгэсэн ажилтны овог, нэр, албан тушаал)

Утас: (Мэдээлэл бэлтгэсэн ажилтантай холбоо барих утасны дугаар)

УРТ ХУГАЦААТ СВОП ХЭЛЦЭЛ

Хэлцэл байгуулсан огноо: оны сарын өдөр
1. Банкны нэр :
2. Хугацаа : хоног
3. Эхний гүйлгээ:	
3.1 Худалдах валют	Ам.доллар
3.2 Хэмжээтоогоор (үсгээр)
3.3 Монголбанкнаас зарласан албан ханш
4. Хүүний төлбөр:	
4.1. Төгрөгийн эх үүсвэрийн хүү	/Энэ журмын нэгдүгээр хавсралтад заасны дагуу/
4.2. Ам.долларын эх үүсвэрийн хүү	/Энэ журмын нэгдүгээр хавсралтад заасны дагуу/
4.3. Хүү тооцох давтамж	3 сар тутам
4.4. Хүү хөрвүүлэх ханш	Тухайн өдөр мөрдөгдөж буй МБ-наас зарласан ханш
4.5. Хүү төлөх хэлбэр	Нэттинг гүйлгээ
5. Буцах гүйлгээ	
5.1. Огноо оны сарын өдөр

МОНГОЛБАНКИЙГ ТӨЛӨӨЛЖ:

БАНКИЙГ ТӨЛӨӨЛЖ:

НӨӨЦИЙН УДИРДЛАГА, САНХҮҮГИЙН
ЗАХ ЗЭЭЛИЙН ЗАХИРАЛ

ЭРХ БҮХИЙ ЗАХИРАЛ

ЦАХИМ ШУУДАНГИЙН ХАЯГ